

“Монголын Газарзүйн Нийгэмлэг” НҮ ТББ-ын  
2026 оны 04 дугаар сарын 03-ны өдрийн  
Удирдах зөвлөлийн хурлаар батлав.



**“МОНГОЛЫН ГАЗАРЗҮЙН НИЙГЭМЛЭГ”  
НИЙГЭМД ҮЙЛЧИЛДЭГ ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ДҮРЭМ**

**Нэгдүгээр бүлэг. Ерөнхий зүйл**

- 1.1. “Монголын Газарзүйн Нийгэмлэг” НҮ ТББ нь Монгол Улсын “Үндсэн хууль”, “Төрийн бус байгууллагын тухай” болон бусад холбогдох хууль дүрэм, олон улсын гэрээ конвенцын хүрээнд үйл ажиллагаа явуулна.
- 1.2. Улс төрийн нам, шашны байгууллага, Аж ахуйн нэгж байгууллага болон бусад хуулийн этгээдүүдээс хараат бусаар үндсэн зорилгынхоо хүрээнд үйл ажиллагаагаа чөлөөтэй, бие даан явуулах ба өөрийгөө удирдан санхүүжүүлнэ.
- 1.3. Төрийн бус байгууллагын нэр: “Монголын Газарзүйн Нийгэмлэг” нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага, хураангуйснаар “МГЗН” НҮ ТББ, англи хэлээр “Mongolian Geographical Society” хураангуйснаар “MGS” NGO гэж байна.
- 1.4. “Монголын Газарзүйн Нийгэмлэг” НҮ ТББ нь хуулийн этгээд мөн бөгөөд туг, тамга, онцлох тэмдэг, албан бичгийн хуудас, уриа, шагнал, хэвлэлтэй байна.
- 1.5. Байгууллагын хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 7-р хороо, Эрхүүгийн гудамж, ШУА-ийн Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн 2-р байранд байрлана.
- 1.6. Цахим хаяг: [mngeographical@mas.ac.mn](mailto:mngeographical@mas.ac.mn), [mngeographical@gmail.com](mailto:mngeographical@gmail.com), вэбсайт нь [www.mgs.org.mn](http://www.mgs.org.mn) байна. Утас: 11-350472, 99991769.
- 1.7. “Монголын Газарзүйн Нийгэмлэг” НҮ ТББ нь 1998 оны 5-р сарын 04-ний өдөр үүсгэн байгуулагдсан.



**Хоёрдугаар бүлэг. Зорилго, зорилт**

- 2.1. “Монголын Газарзүйн Нийгэмлэг” НҮ ТББ нь Газарзүйн шинжлэх ухааны мэдлэг, мэдээллийг нийгэмд түгээн дэлгэрүүлэх, байгалийг зохистой ашиглах, хамгаалах, судлах үйлсэд дэмжлэг үзүүлэх үндсэн зорилготой. Зорилгоо хэрэгжүүлэхийн тулд дараах үйл ажиллагааг явуулна. Үүнд:
  - 2.1.1. Шинжлэх ухааны хурал, зөвлөгөөн, уулзалт, семинар, аялал, экскурс, хээрийн судалгаа зохион байгуулах;
  - 2.1.2. Байгаль, нийгэм эдийн засгийн газарзүйн чиглэлээр суурь, хэрэглээний, технологи хөгжүүлэлтийн судалгаа эрхлэх, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх;
  - 2.1.3. Уур амьсгалын өөрчлөлт, хүрээлэн буй орчны бохирдол, доройтол, менежментийн чиглэлээр нийгэмд дуу хоолойгоо хүргэх, олон нийтэд нээлттэй мэдээлэл түгээх, судалгааны үр дүнг дэлгэрүүлэх, сурталчлах чиглэлээр гэрээт ажил, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх;
  - 2.1.4. Шинжлэх ухаан, эрдэм шинжилгээний танин мэдэхүйн холбогдолтой ном товхимол, газрын зураг, атлас, гадаад, дотоод өгүүлэл, танилцуулга бэлтгэх, хэвлэх, тэдгээрт дэмжлэг үзүүлэх;

- 2.1.5. Газарзүйн олимпиад, уралдаан, тэмцээн, сургалт, радио ба телевизийн нэвтрүүлэг, сошиал контент боловсруулах, зохион байгуулахад оролцох, дэмжлэг үзүүлэх;
- 2.1.6. Монголын газарзүйн шинжлэх ухааныг дотоод болон олон улсад сурталчлах, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах;

#### **Гуравдугаар бүлэг. Бүтэц**

- 3.1. “Монголын Газарзүйн Нийгэмлэг” НҮ ТББ-ын эрх барих байгууллага нь Удирдах зөвлөл байх ба шийдвэр гаргах үйл ажиллагаандаа хамтын удирдлагын зарчмыг баримтална.
- 3.2. “Монголын Газарзүйн Нийгэмлэг” НҮ ТББ нь удирдах зөвлөл, удирдах зөвлөлийн дарга буюу тэргүүн, гүйцэтгэх захирал, зохицуулагч, нягтлан бодогч гэсэн үндсэн бүтэцтэй байх ба шаардлагатай тохиолдолд хөдөлмөрийн хуулийн дагуу үндсэн болон гэрээт ажилтан ажиллуулж болно.
- 3.3. Удирдах зөвлөлд удирдах зөвлөлийн дарга буюу нийгэмлэгийн тэргүүн, гүйцэтгэх захирлыг багтаасан нийт есөөс доошгүй сондгой тооны гишүүдээс бүрдэнэ.
- 3.4. Удирдах зөвлөлийн гишүүн, удирдах зөвлөлийн дарга, гүйцэтгэх захирлыг сонгох, чөлөөлөх асуудлыг удирдах зөвлөлийн хурлаар гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ.
- 3.5. Удирдах зөвлөлийн дарга буюу нийгэмлэгийн тэргүүн, гүйцэтгэх захирал, удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа нь 6 жил байна. Улируулан сонгож болно.

#### **Дөрөвдүгээр бүлэг. Санхүүжилт**

- 4.1. “Монголын Газарзүйн Нийгэмлэг” НҮ ТББ нь өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллах ба өмч хөрөнгө нь халдашгүй байна.
- 4.2. “Монголын Газарзүйн Нийгэмлэг” НҮ ТББ-ын орлого дараах эх үүсвэрээс бүрдэж болно. Үүнд:
  - 4.2.1. Иргэд, аж ахуйн нэгж байгууллагын хандив;
  - 4.2.2. Дүрмийн зорилгоо хэрэгжүүлэхтэй холбогдсон аж ахуйн үйл ажиллагаанаас олсон орлого;
  - 4.2.3. Дүрмийн зорилгоо хэрэгжүүлэхтэй холбогдсон аж ахуйн нэгжийн захиалгат, гэрээт ажил, үйлчилгээнээс олсон орлого;
  - 4.2.4. Төсөл хэрэгжүүлэх зорилгоор улсын төсвөөс олгосон хөрөнгө;
- 4.3. Төрийн бус байгууллагын санхүүгийн жил 1-р сарын 1-ээс эхэлж 12-р сарын 31-нд дуусгавар болно.
- 4.4. Санхүүгийн тайлан тэнцлийг зохих хууль журмын дагуу гаргаж дараа оны 2 дугаар сарын 15-ны дотор татварын албанд тайлагнана.
- 4.5. Төрийн бус байгууллагын үйл ажиллагааны тайланг ТББ-ын тухай хуулийн 23-р зүйлийн 23-ийн 2-т заасны дагуу гаргаж дээрх хугацаанд бүртгэх байгууллагад хүргүүлнэ.
- 4.6. Төр, улс төрийн болон бусад байгууллага, санхүүгийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцож үл болно.

### Тавдугаар бүлэг. Эрх, үүрэг

- 5.1. Удирдах зөвлөл дараах эрх, үүрэгтэй. Үүнд:
- 5.1.1. “Монголын Газарзүйн Нийгэмлэг” НҮ ТББ-ын бодлого, зорилго, үйл ажиллагааны үндсэн чиглэл боловсруулахад оролцох, байр сууриа илэрхийлэх, аливаа асуудлуудыг хэлэлцэж тогтоол гаргах;
  - 5.1.2. Төрийн бус байгууллагын дүрэм болон бусад дүрэм, журмыг сахин биелүүлж эв нэгдлийг ханган ажиллах;
  - 5.1.3. Удирдах зөвлөлийн дарга буюу нийгэмлэгийн тэргүүнийг сонгох;
  - 5.1.4. Удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлөх, сонгох, дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах;
  - 5.1.5. Байгууллагын төсөв хөрөнгийг захиран зарцуулах талаар удирдах зөвлөлийн дарга буюу нийгэмлэгийн тэргүүн, гүйцэтгэх захирлын эрх хэмжээг тогтоох;
  - 5.1.6. Байгууллагын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаа, түүний төсвийг батлах, хяналт тавих;
  - 5.1.7. Гүйцэтгэх захирлын эдлэх эрх, хүлээх үүрэг хариуцлагын хэмжээ, хязгаар, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, хөлс, урамшуулал зэрэг асуудлыг хэлэлцэх;
  - 5.1.8. Хүндэтгэн үзэх шалтгаан, ёс зүйн хариуцлагын улмаас болон өөрийн хүсэлтээр удирдах зөвлөлийн гишүүнээс түдгэлзэх саналаа өгсөн бол түүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлж, орлон ажиллах албан тушаалтныг томилох;
  - 5.1.9. Төрийн бус байгууллагыг өөрчлөн байгуулах, татан буулгах;
- 5.2. Удирдах зөвлөлийн дарга буюу нийгэмлэгийн тэргүүн дараах эрх, үүрэгтэй. Үүнд:
- 5.2.1. Төрийн бус байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдан явуулах;
  - 5.2.2. Удирдах зөвлөлийн хуралдааныг даргалах, чиглүүлэх;
  - 5.2.3. Удирдах зөвлөлийн шийдвэрийг үндэслэн гэрээ хэлцэл байгуулах;
  - 5.2.4. Төрийн бус байгууллагын гүйцэтгэх захирлыг удирдах зөвлөлд санал болгох, томилох;
  - 5.2.5. Удирдах, зөвлөлөөс олгосон эрх хэмжээний хүрээнд төрийн бус байгууллагын санхүү, өмч хөрөнгийн захиран зарцуулах;
  - 5.2.6. Нийгэмлэгийг гадаад, дотоодод төлөөлөх, ажил үүргийн шугамаар гэрээ хэлцэл байгуулах;
  - 5.2.7. Төрийн бус байгууллагын орон нутаг дахь төлөөллүүдийг удирдан зохион байгуулах;
  - 5.2.8. Үндсэн болон гэрээт ажилтныг хөдөлмөрийн гэрээгээр болон хөлсөөр ажиллах гэрээгээр ажиллуулах;
- 5.3. Гүйцэтгэх захирал дараах эрх, үүрэгтэй. Үүнд:
- 5.3.1. Төрийн бус байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд оролцох;
  - 5.3.2. Удирдах зөвлөлийн шийдвэрийг үндэслэн гэрээ хэлцэл байгуулах;
  - 5.3.3. Удирдах, зөвлөлөөс олгосон эрх хэмжээний хүрээнд төрийн бус байгууллагын санхүү, өмч хөрөнгийн захиран зарцуулах;
  - 5.3.4. Нийгэмлэгийг гадаад, дотоодод төлөөлөх, ажил үүргийн шугамаар гэрээ хэлцэл байгуулах;

- 5.3.5. Үндсэн болон гэрээт ажилтныг хөдөлмөрийн гэрээгээр болон хөлсөөр ажиллах гэрээгээр ажиллуулах.
- 5.3.6. Санхүүтэй холбоотой шагнал урамшуулал, тэтгэмж, тусламж болон үйл ажиллагаатай холбоотой зардлын асуудлыг шийдвэрлэх.

5.4. Зохицуулагч дараах эрх, үүрэгтэй. Үүнд:

- 5.4.1. Удирдах зөвлөлийн шийдвэр, үйл ажиллагааны хэрэгжилтийг ханган ажиллах;
- 5.4.2. Үйл ажиллагааны болон холбогдох тайлангуудыг боловсруулж зохих газар нь хүргүүлэх;
- 5.4.3. Төрийн бус байгууллагын электрон шууданд хариу өгөх;
- 5.4.4. Төрийн бус байгууллагын өдөр тутмын бүхий л үйл ажиллагаанд зохицуулалт хийх;

#### **Зургаадугаар бүлэг. Удирдах зөвлөлийн хурал**

- 6.1. Удирдах зөвлөлийн гишүүд хамтын шийдвэр гаргах бөгөөд бүрэн эрхээ хурлаар хэрэгжүүлнэ.
- 6.2. Удирдах зөвлөлийн гишүүдийн 2/3 хувь хуралд оролцсоноор хуралдааны ирцийг хүчинтэйд тооцно.
- 6.3. Удирдах зөвлөл нь ээлжит болон ээлжит бус хуралтай байна.
- 6.4. Ээлжит хурал жилд хоёроос доошгүй удаа хуралдана.
- 6.5. Ээлжит бус хурлын удирдах зөвлөлийн дарга буюу нийгэмлэгийн тэргүүний шийдвэрээр эсвэл удирдах зөвлөлийн 3-аас доошгүй гишүүдийн хүсэлтээр зарлан хуралдуулж болно.
- 6.6. Удирдах зөвлөлийн шийдвэр нь тогтоол байна. Удирдах зөвлөлийн тогтоолд удирдах зөвлөлийн дарга буюу нийгэмлэгийн тэргүүн, удирдах зөвлөлийн зөвлөлийн гишүүд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.
- 6.7. Удирдах зөвлөлийн хурал хийсэн тухай бүр хурлын тэмдэглэл хөтөлнө.
- 6.8. Удирдах зөвлөлийн хурлаас гаргасан шийдвэрийн талаар зарчмын өөр саналтай гишүүний тайлбарыг хурлын тэмдэглэлд хавсаргана.
- 6.9. Удирдах зөвлөл нь хувь хүний асуудлыг нууцаар, бусад асуудлыг илээр санал хураах зарчмаар шийдвэрлэнэ.
- 6.10. Удирдах зөвлөлийн хуралдаанаар шийдвэрлэх асуудлаар гишүүн сонирхлын зөрчилтэй байвал тухайн гишүүн энэ тухайгаа тайлбарлаж санал хураалтанд оролцохгүй. Удирдах зөвлөлийн хуралдаан даргалагч сонирхлын зөрчилтэй байвал хуралдааныг өөр гишүүн даргална.

#### **Долоодугаар бүлэг. Өөрчлөн байгуулах, татан буулгах нөхцөл**

- 7.1. Төрийн бус байгууллагыг эрх бүхий байгууллагын шийдвэрээр хуульд заасан журмын дагуу өөрчлөн байгуулж болно.
- 7.2. Төрийн бус байгууллагыг дараах үндэслэлээр татан буулгана:
  - 7.2.1. Хууль, дүрмийг ноцтой, эсхүл удаа дараа зөрчиж шүүхийн шийдвэрээр албадан татан буулгах шийдвэр гарсан;
  - 7.2.2. Үйл ажиллагаагаа явуулах хугацаа дуусан буюу зорилгодоо хүрсэн учир цаашид үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх шаардлагагүй гэсэн өөрийнх нь шийдвэр гарсан;

**Наймдугаар бүлэг. Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах үндэслэл, журам.**

- 8.1.Төрийн бус байгууллагын дүрэмд оруулах нэмэлт өөрчлөлтийг удирдах зөвлөлөөр хэлэлцэж олонхын саналаар шийдвэрлэнэ.
- 8.2.Удирдах зөвлөлийн шийдвэрээр дүрмийг шинэчилж баталснаар хүчин төгөлдөр болно.

